- 17 сум, 5 тосгонд байрлах нэгж хоорондын 354,015.2 мянган төгрөгийн, 101 байгууллага, аж ахуй нэгжтэй холбоотой 194,542.5 мянган төгрөгийн, 615 иргэнтэй холбоотой 167,585.8 мянган төгрөгийн зэрэг нийт 716,143.5 мянган төгрөгийн бусад авлага.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 16,519.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 7,281.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хангамжийн материал	9,237.6	16,519.3	7,281.7
Бичиг хэргийн материал	642.1	3,304.5	2,662.4
Аж ахуйн материал	4,126.0	10,505.2	6,379.2
Сэлбэг хэрэгсэл	859.8	859.8	-
Түлш, шатах тослох материал	1,380.0	408.5	(971.5)
Бусад хангамжийн материал	2,229.8	1,441.3	(788.5)
Дүн	9,237.6	16,519.3	7,281.7

Эх сурвалж: Аймгийн НДХ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Энэ нь тайлант онд 39,274.6 мянган төгрөгийн материал худалдан авсан, НДЕГ-аас 4,095.0 мянган төгрөгийн маягыг хүлээн авсан болон 2024 оноос газар болохтойгоор холбоотой байгууллагын албан бланк, тамга, тэмдэг болон хаяг, самбар шинэчлэгдсэнээс голлон шалтгаалжээ.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,294,414.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 78,680.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	1,358,657.7	1,279,977.6	(78,680.1)
Барилга, байгууламж, орон сууц	1,387,219.7	1,387,219.7	-
Хуримтлагдсан элэгдэл	(163,915.4)	(203,660.2)	(39,744.8)
Авто-тээврийн хэрэгсэл	12,540.0	12,540.0	-
Хуримтлагдсан элэгдэл	(2,508.0)	(5,016.0)	(2,508.0)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	128,109.9	132,219.6	4,109.7
Хуримтлагдсан элэгдэл	(26,876.7)	(59,353.2)	(32,476.5)
Тавилга, аж ахуйн эд хогшил	111,825.8	112,116.6	290.8
Хуримтлагдсан элэгдэл	(87,737.6)	(96,088.9)	(8,351.3)
Биет бус хөрөнгө	14,437.2	14,437.2	-
Бусад биет бус хөрөнгө	14,437.2	14,437.2	-
Дүн	1,373,094.9	1,294,414.8	(78,680.1)

Эх сурвалж: Аймгийн НДХ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 78,680.1 мянган төгрөгөөр буурсан нь татан буугдсан аймгийн МХГ-аас 4,109.7 мянган төгрөгийн компьютер, 290.8 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан болон тайлант оны хуримтлагдсан элэгдлээс голлон шалтгаалжээ.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 1,209,475.06 мянган төгрөг болж, өмнөх оноос 495,680.53 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	152,159.3	224,535.0	72,375.7
Байгууллагад төлөх өглөг	102.0	102.0	-
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	561,533.2	984,838.1	423,304.9
Дүн	713,794.5	1,209,475.1	495,680.6

Эх сурвалж: Аймгийн НДХ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн дансны үлдэгдэлд дараах өглөгүүд тайлагнагдсан байна. Үүнд:

- Тэтгэврийн даатгалын сангаас иргэдэд олгох 21,580.5 мянган төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас иргэдэд олгох 58,539.7 мянган төгрөг, 17 сум 5 тосгонд байрлах нэгж хоорондын 53,164.6 мянган төгрөг, 74 байгууллага, аж ахуйн нэгжтэй холбоотой 47,816.5 мянган төгрөг, 2742 иргэнтэй холбоотой 43,451.7 мянган төгрөг, банкны үйлчилгээний хураамжийн 102.0 мянган төгрөг зэрэг нийт 224,637.0 мянган төгрөгийн,
- НДШ урьдчилж төлсөн 318 байгууллагын 294,949.6 мянган төгрөгийн, сайн дурын даатгуулагчдаас НДШ урьдчилж төлсөн 1996 иргэний 88,494.3 мянган төгрөгийн, Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулиар нөхөн даатгалын шимтгэлийг дутуу төлснөөс шалтгаалан ажилласан жилээ тооцуулж чадаагүй 306 иргэнтэй холбоотой 6,206.6 мянган төгрөгийн, 0-3 насны хүүхдээ асарч буй 776 эхийн сайн дурын даатгалын шимтгэлд урьдчилан төлсөн 71,589.8 мянган төгрөг, урьдчилж орсон улсын

төсвийн тэтгэврийн санхүүжилт 523,597.8 мянган төгрөгийн зэрэг нийт 984,838.1 мянган төгрөгийн урьдчилж орсон орлого байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 29,004,842.78 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,065,759.77 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	349,539.0	349,539.0	-
Хуримтлагдсан үр дүн	31,585,539.8	28,519,780.0	(3,065,759.8)
Өмнөх үеийн үр дүн	33,946,502.4	31,584,997.3	(2,361,505.1)
Тайлант үеийн үр дүн	(2,360,962.6)	(3,065,217.3)	(704,254.7)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	135,523.8	135,523.8	-
Дүн	32,070,602.6	29,004,842.8	(3,065,759.8)

/ мянган төгрөгөөр/

Эх сурвалж: Аймгийн НДХ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,065,759.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой байна.

3.4.7 Орлогын данс

НДШ-ийн орлого: Тус хэлтэс нь 2023 онд 65,448,491.5 мянган төгрөгийн НДШ-ийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 57,068,971.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого 45,133,545.0 мянган төгрөг,
- Тэтгэмжийн даатгалын шимтгэлийн орлого 5,795,172.2 мянган төгрөг,
- ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн орлого 4,974,001.0 мянган төгрөг,
- Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого 1,141,776.9 мянган төгрөг,
- Нийгмийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасны дагуу хугацаандаа шимтгэлээ төлөөгүй 71 аж ахуйн нэгж, байгууллагад 12,412.2 мянган төгрөгийн, 351 сайн дурын нийгмийн даатгалын даатгуулагчдад 12,064.2 мянган төгрөгийн алдангийг ногдуулж, нийт 24,476.4 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Тэтгэврийн даатгалын шимтгэл	53,915,601.5	45,133,545.0	(8,782,056.5)	83.7
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	5,707,110.0	5,795,172.2	88,062.2	101.5
ҮОМШӨ-ний даатгалын шимтгэл	4,558,336.0	4,974,001.0	415,665.0	109.1
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,267,444	1,141,776.9	(125,667.1)	90.1
НДШ-ийн орлого	65,448,491.5	57,044,495.1	(8,403,996.4)	87.2
Алдангийн орлого.	-	24,476.4	24,476.4	-
Нийт дүн	65,448,491.5	57,068,971.5	(8,379,520.0)	87.2

/ мянган төгрөгөөр/

Тэтгэмжийн даатгалын шимтгэлийн орлого 1.5 хувь, ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн орлого 9.1 хувиар давж, тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого 16.3 хувиар, ажилгүйдлийн даатгалын шимтгэл 9.9 хувиар буюу нийт 12.8 хувь буюу 8,403,996.4 мянган төгрөгөөр тасарсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус хэлтсийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг нийт 133,830,258.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 134,116.7 мянган төгрөгөөр бууруулж, 133,696,141.7 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 110,549.2 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 21,567.5 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан нь голлон нөлөөлсөн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 15,329,479.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн тодотгол хийсэн байна. Үүнд:

- Урсгал засварын зардлыг 65,979.1 мянган төгрөг,
- Урсгал шилжүүлгийг 15,263,500.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 149,025,621.1 мянган төгрөгийн төсөв баталж, НДС-аас 122,473,237.0 мянган төгрөг, улсын төсвөөс 26,552,384.1 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр НДС-аас 67,268,234.8 мянган төгрөгийн санхүүжилт, улсын төсвөөс 26,552,384.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 93,997.0 мянган төгрөг, нийт 93,914,615.9 мянган төгрөгийг авч, үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 144,860,327.7 мянган төгрөг буюу 97.2 хувьтай байгаа нь үйл ажиллагааны зардлыг 102,296.8 мянган төгрөгөөр, НДС-ийн зардлыг 4,062,996.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Имянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,524,545.1	1,437,248.6	(87,296.5)	92.6
2	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	7,425.0	4,264.1	(3,160.9)	57.4
3	Мэдээлэл, сурталчилгааны зардал	2,000.0	411.0	(1,589.0)	20.5
4	Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн хөлс	400.0	28.0	(372.0)	7.0
5	Харуул, хамгаалалтын зардал	300.0	-	(300.0)	0.0
6	Зөвлөл, хороо, комиссын гишүүд	65,536.8	56,519.7	(9,017.0)	86.2
7	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	29,240.9	29,240.9	-	100.0
8	Хуульд заасан үндэслэлээр алба	2,300.0	2,299.7	(0.3)	99.9
9	Бусад тусламж, дэмжлэг	8,453.0	7,892.0	(561.0)	93.4
10	НД-ын тэтгэвэр, тэтгэмж	147,385,420.3	143,322,423.7	(4,062,996.6)	97.2
	Дүн	149,025,621.1	144,860,327.7	(4,165,293.4)	97.2

Эх сурвалж: Аймгийн НДХ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансанд нийт **8,975.0** мянган төгрөгийн /аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс / орлого төвлөрснөөс 6,579.7 мянган төгрөгийг “Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс”-ын бүсийн сургалтын үйл ажиллагаанд, 2,385.0 мянган төгрөгийг “Дээвэр засвар”-т тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн харилцагч байгууллагуудтай тооцоо нийлээгүй, хөрөнгийн тооллого болон хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 104 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 145,788,513.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,457,885.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1,020,519.6 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус хэлтэс нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, кино контент, тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,*
- *Данс бүртгэлд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийн улсын дугаарыг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар сольсон,*
- *Үндсэн болон шуурхай үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаанд зориулан гар утасны зардал гаргаагүй,*
- *Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг байгууллагын үйл ажиллагаанд хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.*

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээлбэл зохих 28 төрлийн 342 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус хэлтсийн 2023 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,081.0 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоон, 15,454.8 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, 389,619.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөгдсөнөөс 2 зөвлөмжийг биелүүлээгүй байна.

Хүснэгт 10. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Имянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	256.0	1	256.0	100.0
	1	825.0	1	825.0	100.0
Албан шаардлага	1	10,485.3	1	10,485.3	100.0
	1	4,969.5	1	4,969.5	100.0
	1	-	1	-	100.0
Зөвлөмж	1	8,798.6	-	-	-
	1	380,821.0	-	-	-
Нийт дүн	7	406,155.4	5	16,535.8	71.4

Эх сурвалж: Аймгийн НДХ-ийн 2022, 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх аудитаар өгсөн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэх, тэтгэвэр, тэтгэмжийн хувийн хэрэгт шаардагдах баримт, бичгийг холбогдох журамд заасны дагуу бүрдүүлж, хавсаргах, тэтгэмж олгосон тухай бүр хувийн хэрэгт бичилт хийж байх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үйл ажиллагаатай холбоотой:

1. Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан сумдад хуваарилж буй санхүүжилт, орлого төвлөрүүлэлт, тэтгэвэр, тэтгэмжийн тооцоолол, баримтын бүрдэл зэргийг бүрэн хэмжээгээр шалгах боломжгүй байсан тул дараагийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах нь зүйтэй юм.

2. 17 сум, 5 тосгонд байрлах нэгж хоорондын 354,015.2 мянган төгрөгийн, 101 байгууллага, аж ахуй нэгжтэй холбоотой 194,542.5 мянган төгрөгийн, 615 иргэнтэй холбоотой 167,585.8 мянган төгрөгийн зэрэг нийт 716,143.5 мянган төгрөгийн бусад авлага тайлагнагдсан байна.

Эдгээр авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулсан /эзэн холбогдогч нь тодорхойгүй авлагыг холбогдох газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх/ эсэхийг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай байна.

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. НДЕГ-ын даргын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/80 дугаар тушаал болон НДЕГ-ын Санхүү, бүртгэлийн газрын даргын 2023 оны 05/1124 дүгээр албан бичгээр “2022 оны санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан **балансын урамшууллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн олгож болно**” гэж хууль , эрх зүйн үндэслэлгүй шийдвэр гаргаж, ирүүлсэн байна.

Уг албан бичгийн дагуу дараах албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 40.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал тус бүр нэг сарын үндсэн цалингийн 80.0 хувьтай тэнцэх буюу нийт **3,020.8** мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна. Үүнд:

- Санхүү, бүртгэлийн тасгийн дарга бөгөөд ахлах нягтлан бодогч Х.Сэлэнгэмөрөнд 802.1 мянган төгрөг,
- Төлөвлөлт нэрийн дансны мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогч А.Баасансүрэнд 739.6 мянган төгрөг,
- Сангийн нягтлан бодогч М.Баярчимэгт 739.6 мянган төгрөг,
- Сангийн нягтлан бодогч Н.Уранчимэгт 739.6 мянган төгрөг,

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно.”, 15.1.3 : “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. НДЕГ-ын даргын 2023 оны 01/2253 дугаар албан бичгийн дагуу газар, байгууллагын гадна, дотор хаягийг солих, шинэчлэхэд зориулан бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд хамаарах **15,000.0** мянган төгрөгийг бага, үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардалд тусган төлөвлөсөн байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын 210406: Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс: “Байгууллагын албан байрны тохижилт, цэвэрлэгээ болон аж ахуйн хэрэгцээний зориулалтаар худалдан авсан бараа, материал, эд зүйлс, ... бага үнэтэй буюу түргэн элэгдэх эд зүйлсийг худалдан авч шууд зарлагдах үед гарсан зардлыг энэ ангилалд бүртгэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 247,510.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,248.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 246,262.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлэн, 3 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Албан хаагчдыг аймаг, сумдад албан томилолтоор ажилласан хугацаанд хоолны хөнгөлөлтийн **1,248.0** мянган төгрөгийг давхардуулан тооцож, олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ. 20.2.5: “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гаргахас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон хоолны хөнгөлөлтийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1. Бүрдэл дутуу анхан шатны баримтаар нийт **62,189.2** мянган төгрөгийн дараах ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Үүнд:

- Аймгийн НДХ болон Мандал, Сайхан сумын нийгмийн даатгалын тасгийн урсгал засварын төсөв, үнийн тооцоо судалгааг хийлгүйгээр нийт 58,931.1 мянган төгрөгийг зарцуулсан,
- Жолоочийн тосцооны хуудсанд ирсэн, явсан болон зарцуулсан хугацаа, спидометрийн заалтыг бүрэн хөтлөлгүйгээр нийт 3,258.1 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан,

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр “Жишиг норм батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ын холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүчин төгөлдөр, баталгаажсан анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэн, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Аудитын явцад Мандал, Сайхан, Сүхбаатар сумдын өндөр насны, тэжээгчээ алдсаны, тахир дутуугийн тэтгэвэр, ажилгүйдлийн тэтгэмж олголтыг түүвэрлэн шалгахад хувийн хэргийн бүрдлийн шаардлагыг хангаагүй баримт, материалыг үндэслэн **184,073.3** мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг тооцож олгосон байна. Үүнд:

- **Ажилгүйдлийн тэтгэмж:**

Тэтгэмжийн хувийн хэрэгт олголт хийсэн тухай бүр тэмдэглэгээ хийлгүйгээр болон ажлаас халсан тухай шийдвэрийн эх хувийг бус хуулбарыг хавсарган нийт **99,514.1** /Мандал сум – 49,651.3, Сайхан сум – 23,416.7, Сүхбаатар сум – 26,446.1/ мянган төгрөгийн тэтгэмжийг тооцож, олгосон байна.

Энэ нь НДҮЗ-ийн 2021 оны “Журам шинэчлэн батлах тухай” 09 дүгээр тогтоолын 5.2-т “Ажлаас халагдсан ... 5.2.3: **Ажлаас халсан тухай шийдвэр, ...**”, 6.2-т “**Даатгуулагчид олгосон тэтгэмжийн хэмжээг сар бүр тэтгэмж олгох тухай мэдэгдэл, ажилгүйдлийн даатгалын сангийн харилцах дансны баримттай тулган шалган, баталгаажуулж, тэтгэмжийн олголтыг түүний хувийн хэрэгт тухай бүр тэмдэглэнэ**” гэсэн заалтыг зөрчсөн байна.

- **Өндөр насны, тэжээгчээ алдсаны, тахир дутуугийн тэтгэвэр:**

Тэтгэврийн хувийн хэрэгт иргэний үнэмлэх, төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдийн төрсний гэрчилгээний мэдээллийг төрийн мэдээллийн “Хур” системээс авалгүйгээр хуулбарыг хавсарган нийт **84,559.2** /Мандал сум – 38,461.4, Сайхан сум – 13,423.4, Сүхбаатар сум – 32,674.4/ мянган төгрөгийн тэтгэврийг тооцож, олгосон байна.

Энэ нь НДЕГ-ын даргын 2022 оны А/31 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Тэтгэвэр тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам”-ын Санамж 2-т “Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан даатгуулагч (иргэн)-ийн энэ журмын 2.1.2, 2.1.9-д заасан баримт бичгийг **төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системээс, ... авна.**” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тэтгэвэр, тэтгэмжийн хувийн хэрэгт шаардагдах баримт, бичгийг холбогдох журамд заасны дагуу бүрдүүлж, хавсаргах, тэтгэмж олгосон тухай бүр хувийн хэрэгт бичилт хийж байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөрөнгийн тооллого, бүртгэлтэй холбоотой асуудал

1.1.1 Илрүүлэлт: Аж ахуйн нэгж байгууллагуудтай тухай бүр гэрээ байгуулан бичиг хэрэг, барилгын засварын материалыг худалдан авч, зарцуулсан боловч жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “*... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулж, удирдах*” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Харилцагч байгууллагуудтай санхүүгийн тайлан гаргахын өмнө тооцоо нийлсэн актаар үлдэгдлийг баталгаажуулж байх.

1.2.1 Илрүүлэлт: Жилийн эцэст эд, хөрөнгийн тооллого хийсэн боловч тооллогын явц, үр дүнг комиссын хурлаар хэлэлцэж, байгууллагын удирдлагаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “*... үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “*Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар*”-ын НХМаягт БМ-8-д “*Тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд зааврын дагуу үнэн зөв, чанартай явуулж тооллогын явц үр дүнг комиссын хурлаар хэлэлцэж, тооллогын бүртгэлийг 2 хувь үйлдэж байгууллагын удирдлагад танилцуулан батлуулж, санхүүгийн албанд хүргүүлэх үүрэгтэй*” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

1.2.2 Илрүүлэлт: Тооллого, тооцооны үр дүнг тооцож, шийдвэрлэж байх.

1.3.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 21 нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.3.2 Өгссөн зөвлөмж: Хөрөнгийг ашиглах бол дахин үнэлэх буюу актлах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5¹ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон	1	1,248.0	1	1,248.0								
Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан.	1	62,189.2			1	62,189.2						
Тэтгэвэр, тэтгэмжийн хувийн хэргийн бүрдлийн шаардлагыг хангаагүй баримт, материалыг үндэслэн тэтгэвэр, тэтгэмжийг тооцож олгосон.	1	184,073.3			1	184,073.3						
Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй.	1						1					
Тооллогын үр дүнг тайлагнаагүй.	1						1					
Хөрөнгийг дахин үнэлээгүй	1						1					
Дүн	6	247,510.5	1	1,248.0	2	246,262.5	3					

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.